



**МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ**

Засгийн газрын VII байр, Энхтайваны өргөн чөлөө 51,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13340
Утас: 26 35 31, Факс: (976-11) 45 81 12,
Цахим шуудан: info@mod.gov.mn
Цахим хаяг: www.mod.gov.mn

2025.12.11 № 1в/4565

танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Батлан хамгаалах салбарын 2025 онд ёс зүйн чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хүргүүлж байна.

Хавсралт 7 хуудастай.

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны
12 дугаар сарын 11-ний өдрийн
1в/4565 дугаар албан бичгийн хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРААС ЁС ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР 2025 ОНД АВЧ
ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Батлан хамгаалах салбар нь 2025 онд “Батлан хамгаалах яамны стратеги төлөвлөгөө”-ний зорилт 7.2.-д “Цэргийн алба хаагчийн эрх зүйн хэм хэмжээ, цэргийн нийтлэг дүрмүүдийн хэрэгжилт, сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах” зорилтын хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын байдалд хяналт тавьж, ашиг сонирхлын зөрчил болон үүсэж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, цэргийн нийтлэг дүрмүүдийн хэрэгжилтийн байдлыг хангах ажил, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

Нэг. Дэд хорооны үйл ажиллагааны талаар:

Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2.4. дэх заалтад 40 ба түүнээс цөөн төрийн алба хаагчтай байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороо нь 3 гишүүн, 41-90 бол 5 гишүүн, 91-ээс дээш бол 7 гишүүнтэй байна гэсний дагуу батлан хамгаалах салбарт нийт 91 дэд хороонд 484 гишүүн журмын дагуу ажиллаж байна.

д/д	Нэр	БХЯ	Яамны харьяа байгууллага	ЗХЖШ	Төрлийн цэргийн командлал, удирдах газар	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар	Нийт
1	Дэд хороо	1	16	1	4	69	91
2	Гишүүн	7	70	7	18	382	484

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-д заасны дагуу Батлан хамгаалах яамны Ёс зүйн дэд хороо болон яамны харьяа агентлаг, аж ахуйн нэгж байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүд урамшуулал авч байгаа болно.

Ёс зүйн дэд хороо, Удирдлагын академиас зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн хуулийн зөвлөх М.Пүрэвсүрэн, Цэргийн төв эмнэлгийн эдийн засагч О.Батзаяа, Цэргийн дүү бүжгийн эрдмийн чуулгын хууль, хөдөлмөр хамгааллын офицер, дэслэгч Ү.Санжаасүрэн нарыг хамруулж, дотооддоо сургалтыг зохион байгуулах чадавхыг бүрдүүлж ажиллалаа.


Удирдлагын академиас 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Ёс зүй, хүний эрх” сургалтад Ёс зүйн дэд хорооны гишүүн Л.Ганзориг хамрагдсан байна.

Хоёр. Хариуцсан салбар, байгууллагад ёс зүйн зөрчил гарч байгаа болон үүсэж болзошгүй эрсдэлд дүн шинжилгээ хийсэн, эрсдэлийг бууруулахаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 1.1.1.-д “байгууллага албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг Ёс зүйн хорооноос баталсан аргачлалын дагуу жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх сургалтыг 2026 оны 01 дүгээр сард салбарын хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөж байна.

Батлан хамгаалах салбар нь Цэргийн алба хаагчдын холбогдсон гэмт хэрэг, ёс зүйн болон бусад зөрчлийн түвшин, хөдөлгөөн, тархалт, шалтгаан нөхцөлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудаас гэмт хэрэг, зөрчлийн судалгаа, мэдээллийг улирал бүр авч, дүн шинжилгээнд суурилсан арга хэмжээг авч хэрэгжүүлж хэвшсэн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд яамны харьяа аж ахуйн нэгж байгууллага, Зэвсэгт хүчний анги байгууллагын ёс зүйн дэд хороод бие бүрэлдэхүүний ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ёс зүйн дэд хорооны баримт бичгийн самбарыг байршуулан цаг үеийн мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна.



“Ёс зүй, сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлэг”-үүдийг томилон Зэвсэгт хүчний 232, 327, 338 дугаар ангиуд болон 065 дугаар ангийн 085,086, 281, 329 дүгээр салбар, 124 дүгээр ангийн 168 дугаар салбарууд, Зэвсэгт хүчний 330, 186, 110, 234 дүгээр ангиуд, 065 дугаар ангийн 322 дугаар салбар зэрэг нийт 40 гаруй анги байгууллагад ажиллан ёс зүй, сэтгэл зүйн сургалт, оношилгоо, зөвлөгөө өгсөн байна.

Гурав. Хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт болон өгсөн зөвлөмж:

Батлан хамгаалах яамны харьяа аж ахуйн нэгж байгууллагад 2025 онд шинээр томилогдсон албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн ойлголт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг тухай бүрд нь зохион байгуулан ажилласан.

Батлан хамгаалах яамны харьяа аж ахуйн нэгж байгууллагын 15 ажилтан, албан хаагчдыг Удирдлагын академийн дэргэдэх Төрийн албаны сургуулийн “Төрийн албан хаагчдад зориулсан ёс зүйн цахим сургалт”-д хамруулж, Ёс зүйн II түвшний үнэмлэх-6, Ёс зүйн III түвшний үнэмлэх-9 хүн тус тус авсан.

Багшийн хөгжил, цахим сургалтын төв, Амжилтын танхим сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулсан “Ажлын байрны сэтгэл ханамжийг сайжруулах замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх нь” 5 модуль сургалтад Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн 30 гаруй багш хамруулсан. Тус сургалт нь:

1. Хүний зан төлөв, ёс суртахуун;
2. Ухамсрын түвшин;
3. Сэтгэл хөдлөл чиглүүлэх арга зүй;
4. Энерги, мэдрэмжийн менежментийн аргачлал;
5. Ажил мэргэжлийн карьер төлөвлөлт зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан.

Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/205 дугаар тушаалаар баталсан “Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг яамны харьяа аж ахуйн нэгж байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын нийт офицер, ахлагч нарт сурталчлан таниулж, ёс зүйн андгай өргүүлж, гарын үсгээр баталгаажуулах ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 15-30-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Батлан хамгаалахын удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтаар Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, ШУА-ын академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор, пропессор С.Нарангэрэлийг урьж, “Хүмүүн байхын учир ёс суртахуунд оршвой” гэсэн сэдвээр илтгэл хэлэлцүүлэг хийлгэсэн.

Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчийн 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ны өдрүүдэд бүх харьяа байгууллагуудад “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, баримтлах зарчим, харилцаа хандлага” сэдвийн хүрээнд сургалт зохин байгуулсан.

Сургалтад Батлан хамгаалах яамны харьяа 15 байгууллагын нийт 685 офицер, ахлагч, сонсогч, ажилтан, албан хаагч хамрагдсан. Сургалтыг Батлан хамгаалах яамны ёс зүйн дэд хорооны дарга хурандаа Т.Мөнхбаяр, гишүүн Л.Ганзориг, Монгол Улсын Ёс зүйн хорооны Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хариуцсан референт З.Соёлмаа, ахлах мэргэжилтэн Д.Мөнхжин нар хийсэн.



Орон нутгийн болон Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, ангид байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ёс зүйн талаарх сургалтыг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн багш нартай хамтран Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, ангийн алба хаагчдад 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 04 дүгээр сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Мөн Нийслэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, ахлагч нарын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн сургалтаар “Төрийн албан хаагчийн ёс зүйн үнэт зүйл” сэдвээр Удирдлагын академийн багш доктор, дэд профессор Т.Аззаяа, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга П.Булганмаа тус тус лекц орсон.



Монгол Улсын хэмжээнд кибер орчинд гэмт хэрэг үйлдэгдэх нь нэмэгдэж байгаатай холбогдуулан командлалын цэргийн алба хаагчдад цахим орчин дахь ёс зүйн талаар мэдлэг олгох зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын ахлах мөрдөгч цагдаагийн ахмад Б.Мөнхнаранг 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдөр урьж “Цахим орчин дахь гэмт хэрэг, цахим мөрийтэй тоглоом” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Зэвсэгт хүчний 10 гаруй анги байгууллагын алба хаагч болон хугацаат цэргийн алба хаагчдад “Хос төв” сургалтын багш П.Хулан “Стресс менежмент, ёс зүй” сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 18-наас 03 дугаар сарын 07-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдсан Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын хууль, хөдөлмөр хамгааллын офицер, дэслэгч Ү.Санжаасүрэн “Батлан хамгаалахын сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга хариуцлагыг чангатгах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгавар, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэглээ сэдэвт 1 цагийн сургалтыг яамны харьяа 15 байгууллагын албан хаагчдыг хамруулан 2025 оны 10, 11 дүгээр саруудад зохион байгууллаа.



Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын Үндэсний хөгжмийн албаны уран бүтээлчид Хавдар судлалын үндэсний төвийн “Хавдрын эсрэг хөгжмөөр нэгдэцгээе” хөгжим эмчилгээний хөтөлбөрийн хүрээнд ардын сайхан дуу, аялгуугаар эмнэлгийн үйлчлүүлэгчид хийгээд тэдний ар гэрийнхний сонорыг мялааж, сэтгэлийг анагаах эмчилгээ үйлчилгээ үзүүллээ.

АТГ-ын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Ж.Мөнхжаргал “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сэдэвт сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 10-30-ны өдрүүдэд Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 34 алба хаагч, ҮБХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академид “Нэгтгэл, ангийн захирагчийн дамжаа”-нд суралцаж буй Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн 20 гаруй захирагч нарт зохион байгуулсан.

ХЭҮК-ын гишүүн Я.Цэлмэнг урьж Батлан хамгаалах яамны бүрэлдэхүүн болон харьяа байгууллагуудын удирдах бүрэлдэхүүнд “Хүний эрх, ёс зүй” сэдэвт сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Батлан хамгаалах яаманд зохион байгуулсан.



ЦДБЭЧ-ын хамт олон 2025 онд цэргийн албанаас бэлтгэлээр чөлөөлөгдсөн хамт олныхоо халуун талархал, бахархал хүндэтгэлийг хүлээсэн ёс зүй, сахилга хариуцлагатай 5 ахлагч нарт зориулан

“Хүндэтгэн дуурсах алдар” өдөрлөгийг 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгууллаа.



Батлан хамгаалах яамны ёс зүйн дэд хороо, “Дуулга” студийн уран бүтээлчид Төрлийн цэргийн командлалын цэргийн алба хаагчдыг оролцуулан 1 минут 30 секундйн “Цэргийн алба хаагчийн Ёс зүйн андгай” шторкийг бэлтгэн БХЯ, ЗХЖШ, “Дуулга” студийн цахим хуудсуудад байршуулан олон нийтэд сурталчилсан бөгөөд нийт 29400 хүнд хүрсэн байна.

Мөн алба хаагчдын ёс зүй, харилцаа хандлагад чиглэсэн богино хэмжээний дүрс бичлэг, контент бүтээх төсөл боловсруулж, “Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг сурталчилсан богино хэмжээний дүрс бичлэгийг бэлтгэн салбарын цахим хуудсаар сурталчилж 17 мянган хүнд хүрээд байна. Уг дүрс бичлэгийг youtube сувагт байршуулан Ёс зүйн хорооны цахим хуудсаар олон нийтэд сурталчилсан.

Монгол Улсын ёс зүйн хорооноос явуулсан “Хүндэлье-Энэрье” сарын аяны хүрээнд Батлан хамгаалах яамны ёс зүйн дэд хорооны гишүүд нөлөөллийн контент хийх хуваарь гарган, яамны дотоод сүлжээнд байршуулан ажилласан.

Дөрөв. Ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэх талаар тайлан, шийдвэрийн бүртгэл:

Батлан хамгаалах яам, харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудын Ёс зүйн дэд хороонд 2025 оны жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол ирүүлээгүй байна. (2023 онд 6 зөрчил, 2024 онд 4 зөрчил, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар ёс зүйн зөрчлийн мэдээлэл ирээгүй байна.)



Тав. Үр дүн

Батлан хамгаалах салбарын хэмжээнд ёс зүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, харилцаа, хандлагыг сайжруулах ажлыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд гарч байна. Үүнд:

-Алба хаагчдын ёс суртахууны мэдлэг, хандлага, харилцаа сайжирч, байгууллагын дотоод соёлд эерэг нөлөө үзүүлэн ёс зүйн зөрчил, гомдлын тоо жил бүр буурч байна.

-Эрдэмтэн доктор, профессоруудын оролцоотой сургалт, уулзалтаар алба хаагчдын ёс зүй, харилцаа, хандлагын талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, соён гэгээрүүлэх ажлын оролцооны соёл төлөвшиж, ёс зүйн дэд хороодын сургалт, соён гэгээрүүлэх ажил тогтмолжсон.

-Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн цэргийн сэтгэл зүйчдийн орон тоо өмнөх оноос 12 хувиар нэмэгдсэн нь сэтгэл зүй, ёс суртахууны талаар зөвлөгөө мэдээлэл авах алба хаагчид тогтмол өсөж, сургалт соён гэгээрүүлэх ажлын чанар хүртээмж улам сайжирсан.

Зургаа. Дүгнэлт

Батлан хамгаалах салбар нь “Хандлагаа өөрчилж, хариуцлагаа нэмэгдүүлье” уриалгыг бодит ажил болгон хэрэгжүүлж, ёс зүй, хариуцлагын соёл, сэтгэл зүйн дэмжлэг, харилцааны өөрчлөлтийг төлөвлөн, хэрэгжүүлснээр тодорхой үр дүнд хүрч байна.

Ёс зүйн дэд хороо нь хууль, журмын хүрээнд үйл ажиллагаагаа тогтмол, үр дүнтэй хэрэгжүүлж, сургалт, зөвлөмж, судалгаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж, ёс зүйг байгууллагын соёлын үндэс болгон төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөн ажиллаж байна.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ